

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Л.БЯМБАСҮРӨН

НИЙЛҮҮЛЭГЧ:  
“БАЯНГОЛ МЕД ХХК-ИЙН ЗАХИРАЛ

СХӨХИЙ

БУСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮДИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ  
/БАГЦ-4 ЗӨӨВРИЙН РЕНТГЕН АППАРАТ C-ARM (МЭС ЗАСЛЫН) /

Дугаар № 2021/36 / 01 .....

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” (цаашид “захиалагч” гэх), нэгтгэж талаас “Баянол мед” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Бусийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, багц-4 Зөөврийн рентген аппарат C-arm /Мэс заслын/ (цаашид “ажил” гэх)-тэй холбогдон захиалагч, нийлүүлэгчдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь Бусийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, багц-4 Зөөврийн рентген аппарат C-arm /Мэс заслын/ нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Эрүүл мэндийн яам нийлүүлэгч байгууллагын ажлын үе шатны явцыг хянан баталгаажуулж санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.

4. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар ажлыг 2,150,500,000 (хоёр тэрбум нэг зуу тавин сая таван зуу мянган) төгрөгөөр Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.5 бусад хэсэгт батлагдсан 132,596,000 (нэг зуун гучин хоёр тэрбум таван зуун ерэн зургаан сая) төгрөгөөс санхүүжүүлэх бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулсан тухай Эрүүл мэндийн яамны дүгнэлтийг үндэслэн санхүүжүүлнэ. Урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 30 хүртэл хувийг санхүүжүүлж болно.

5. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн ажлыг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 120 хоногийн дотор хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Зөөврийн рентген аппарат C-arm /Мэс заслын/	БНСУлс	Anuvue 500R	17

6. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд талууд харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

7. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах мэдэгдэл;

Үнийн санал;

Үнийн хуваарь;

Техникийн тодорхойлолт, харьцуулсан хүснэгт;

Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/

Барааны танилцуулга

Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

Харьцуулсан хүснэгт

8. Гэрээ нь энд дурдсан ажил гүйцэтгэлийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

9. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

10. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн гүйцэтгэх ажлын болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**Гэрээг хянасан:**

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн *Г.Бат-Эрдэнэ* Г.Бат-Эрдэнэ

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЭМДЕГ-ЫН Тамгын газрын дарга



Г.Бат-Эрдэнэ

ЭМДЕГ-ЫН Санхүү, бүртгэлийн хэлтсийн  
дарга

*Л.Нарантуяа* Л.Нарантуяа

ЭМДЕГ-ЫН Тамгын газрын Эрхэзүйн  
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Т.Одонтогоо

Хаяг: Эрүүл мэндийн даатгалын  
өрөнхий газар, Улаанбаатар-17032,  
Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн  
өргөн чөлөө  
Утас: 7010-1152  
Факс: 7010-0005

Ерөнхий менежер

Ц.Төгөлдөр

Хаяг: “Баянгол дүүрэг, 11-р хороо, 21-а байр  
Утас: 7010-1313, 9610-0000  
И-мэйл: info@bayangolmed.mn  
Дансны дугаар: 475006054  
Худалдаа хөгжлийн банк